



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
Мөрөн хот  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 88090438 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)  
Аудитор: Л.Мандахнаран  
Утас: 92118277 Цахим хаяг: [mandakhnaranl@audit.gov.mn](mailto:mandakhnaranl@audit.gov.mn)  
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн  
Ерөнхий захирал: Т.Батсайхан  
Утас: 99010760 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)  
Аудитын менежер: Г.Оюунгэрэл  
Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)  
Ахлах аудитор: Д.Алтайбаяр  
Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	15
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АИТХТ	Аймгийн иргэдийг төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/190  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ДОГСМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,272,838.06</b>	<b>185,937,330.57</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>00.00</b>	<b>34,271,170.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>00.00</b>	<b>34,271,170.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>00.00</b>	<b>34,271,170.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	00.00	34,271,170.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>43,263,700.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	43,263,700.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>60,272,838.06</b>	<b>108,402,460.57</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>12,759,329.31</b>	<b>35,499,564.13</b>
35130	Эм боох материал	12,759,329.31	35,499,564.13
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>47,513,508.75</b>	<b>72,902,896.44</b>
35410	Бичиг хэргийн материал	434,100.00	741,500.00
35420	Аж ахуйн материал	16,540,670.00	18,055,570.00
35430	Сэлбэг хэрэгсэл	82,000.00	1,349,099.99
35440	Түлш, шатах тослох материал	4,222,807.00	4,117,620.00
35450	Барилгын засварын материал	202,890.00	202,890.00
35460	Хүнсний материал	8,902,941.75	11,476,247.50
35470	Бусад хангамжийн материал	17,128,100.00	36,959,968.95
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,783,003,113.68</b>	<b>1,865,343,594.83</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,783,003,113.68</b>	<b>1,865,343,594.83</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,747,195,113.68</b>	<b>1,843,285,594.83</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,615,871,546.28	1,615,871,546.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64,386,476.40	-102,605,033.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,703,330.55	49,166,896.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,291,869.57	-14,630,137.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	254,471,277.93	252,105,504.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-190,912,296.20	-39,438,045.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,940,526.00	41,604,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,736,644.26	-11,726,332.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,306,459.80	62,306,459.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,770,740.45	-9,369,362.61
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>35,808,000.00</b>	<b>22,058,000.00</b>
39301	Програм хангамж	15,725,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-725,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,808,000.00	20,808,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,843,275,951.74</b>	<b>2,051,280,925.40</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,843,275,951.74</b>	<b>2,051,280,925.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,843,275,951.74</b>	<b>2,051,280,925.40</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	435,284,554.00	435,284,554.00
51101	Өмч: - төрийн	435,284,554.00	435,284,554.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,317,261,766.04</b>	<b>1,526,576,189.70</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,317,261,766.04	1,318,571,216.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	208,004,973.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,729,631.70	89,420,181.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,843,275,951.74</b>	<b>2,051,280,925.40</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>777,825,830.65</b>	<b>1,368,337,901.75</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>84,419,470.65</b>	<b>310,942,071.75</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>84,419,470.65</b>	<b>310,942,071.75</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,769,257.52	250,191,363.75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,769,257.52	250,191,363.75
120005	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	00.00	60,750,708.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,406,360.00</b>	<b>301,054,030.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>637,839,500.00</b>	<b>71,290,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,839,500.00	71,290,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	756,341,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,774,600.00</b>	<b>209,951,740.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	118,400.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	162,293,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,400.00	45,839,840.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,357,800.00	1,618,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,792,260.00</b>	<b>19,811,390.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,792,260.00	19,811,390.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>764,930,711.92</b>	<b>1,142,121,558.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>764,930,711.92</b>	<b>1,142,121,558.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>764,030,711.92</b>	<b>1,094,005,057.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>478,801,373.00</b>	<b>557,888,770.00</b>
210101	Үндсэн цалин	275,304,273.00	260,945,820.00
210102	Нэмэгдэл	144,480,329.00	154,664,107.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,085,000.00	9,620,000.00
210104	Урамшуулал	50,931,771.00	117,448,454.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	15,210,389.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>63,760,500.00</b>	<b>68,022,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,548,500.00	47,867,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,803,000.00	5,038,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,842,400.00	4,031,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	960,600.00	1,007,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,606,000.00	10,077,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>58,271,575.00</b>	<b>63,773,331.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,318,300.00	5,651,422.00
210302	Түлш, халаалт	54,908,075.00	58,082,209.25
210303	Цэвэр, бохир ус	45,200.00	39,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,618,058.76</b>	<b>38,876,153.75</b>
210401	Бичиг хэрэг	2,386,550.00	2,930,600.00
210402	Тээвэр, шатахуун	13,254,302.00	19,239,973.75

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,833.00	3,260,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,567,373.76	13,444,980.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,547,224.68</b>	<b>270,740,806.22</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,113,129.58	259,204,261.97
210502	Хоол, хүнс	10,434,095.10	11,536,544.25
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,671,400.00</b>	<b>2,732,900.01</b>
210604	Урсгал засвар	5,671,400.00	2,732,900.01
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>910,000.00</b>	<b>743,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	910,000.00	743,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,166,037.00</b>	<b>1,034,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,475,837.00	379,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	239,400.00	69,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	67,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,725,000.00	00.00
210807	Газрын төлбөр	293,000.00	93,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	710,300.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>63,284,543.48</b>	<b>90,193,096.25</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,640,000.00	9,150,536.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,644,543.48	81,042,560.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>900,000.00</b>	<b>48,116,501.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>44,900,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	44,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>200,000.00</b>	<b>3,216,501.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	200,000.00	3,216,501.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>12,895,118.73</b>	<b>226,216,343.27</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>18,211,369.61</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	18,211,369.61
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-18,211,369.61</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>12,895,118.73</b>	<b>208,004,973.66</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	1,317,261,766.04	1,843,275,951.74
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	1,317,261,766.04	1,843,275,951.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	1,309,450.00	1,309,450.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,284,554.00	1,318,571,216.04	1,844,585,401.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-1,309,450.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	208,004,973.66	208,004,973.66
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	1,526,576,189.70	2,051,280,925.40

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>693,406,360.00</b>	<b>1,014,132,130.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>693,406,360.00</b>	<b>1,014,132,130.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>637,839,500.00</b>	<b>71,290,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	637,839,500.00	71,290,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	756,341,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,774,600.00</b>	<b>166,688,040.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	118,400.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,400.00	45,839,840.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,357,800.00	1,618,900.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	119,029,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,792,260.00</b>	<b>19,811,390.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,792,260.00	19,811,390.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>686,243,260.00</b>	<b>895,269,960.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>686,243,260.00</b>	<b>895,269,960.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>685,343,260.00</b>	<b>847,153,459.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>478,801,373.00</b>	<b>557,888,770.00</b>
210101	Үндсэн цалин	275,304,273.00	260,945,820.00
210102	Нэмэгдэл	144,480,329.00	154,664,107.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,085,000.00	9,620,000.00
210104	Урамшуулал	50,931,771.00	117,448,454.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	15,210,389.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>63,760,500.00</b>	<b>68,022,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,548,500.00	47,867,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,803,000.00	5,038,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,842,400.00	4,031,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	960,600.00	1,007,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,606,000.00	10,077,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,562,700.00</b>	<b>64,993,358.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,318,300.00	5,651,422.00
210302	Түлш, халаалт	53,199,200.00	59,302,236.00
210303	Цэвэр, бохир ус	45,200.00	39,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,650,900.00</b>	<b>30,614,360.00</b>
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	2,238,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,317,867.00	17,914,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	409,833.00	3,160,600.00
210404	Ном, хэвлэл	00.00	165,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	2,191,000.00

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,873,200.00	4,945,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,461,800.00</b>	<b>86,685,215.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,660,800.00	70,575,365.00
210502	Хоол, хүнс	9,306,000.00	14,109,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,495,000.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,860,300.00</b>	<b>26,885,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	451,900.00	20,901,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,984,000.00
210604	Урсгал засвар	6,408,400.00	4,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>910,000.00</b>	<b>743,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	910,000.00	743,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,435,687.00</b>	<b>2,121,020.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,539,837.00	465,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	239,400.00	69,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	67,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,725,000.00	00.00
210807	Газрын төлбөр	293,000.00	93,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,915,950.00	1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,900,000.00</b>	<b>9,200,236.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,900,000.00	9,200,236.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>900,000.00</b>	<b>48,116,501.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>700,000.00</b>	<b>44,900,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	44,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>200,000.00</b>	<b>3,216,501.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	200,000.00	3,216,501.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>7,163,100.00</b>	<b>118,862,170.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,163,100.00</b>	<b>84,591,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,163,100.00</b>	<b>84,591,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,163,100.00</b>	<b>84,591,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,163,100.00	84,591,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-7,163,100.00</b>	<b>-84,591,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>34,271,170.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>34,271,170.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	/төгрөг/ Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	869,341,400.0	809,856,419.0	59,484,981.0	93.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	869,341,400.0	809,856,419.0	59,484,981.0	93.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	869,341,400.0	809,856,419.0	59,484,981.0	93.2
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	518,219,800.0	475,780,394.0	42,439,406.0	91.8
210101	Үндсэн цалин	276,389,800.0	260,945,820.0	15,443,980.0	94.4
210102	Нэмэгдэл	170,425,800.0	154,664,107.0	15,761,693.0	90.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,500.0	9,620,000.0	2,380,500.0	80.2
210104	Урамшуулал	42,267,700.0	35,340,078.0	6,927,622.0	83.6
210105	Гэрээт ажлын хөлс	17,136,000.0	15,210,389.0	1,925,611.0	88.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,959,700.0	68,022,400.0	1,937,300.0	97.2
210201	Тэтгэврийн даатгал	49,231,000.0	47,867,700.0	1,363,300.0	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,182,200.0	5,038,700.0	143,500.0	97.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,145,800.0	4,031,000.0	114,800.0	97.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,036,300.0	1,007,600.0	28,700.0	97.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,364,400.0	10,077,400.0	287,000.0	97.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,290,900.0	64,074,399.0	3,216,501.0	95.2
210301	Гэрэл, цахилгаан	6,193,300.0	5,392,463.0	800,837.0	87.1
210302	Түлш, халаалт	60,149,200.0	58,642,236.0	1,506,964.0	97.5
210303	Цэвэр, бохир ус	948,400.0	39,700.0	908,700.0	04.2
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,085,000.0	26,575,120.0	2,509,880.0	91.4
210401	Бичиг хэрэг	1,500,000.0	1,238,000.0	262,000.0	82.5
210402	Тээвэр, шатахуун	15,555,000.0	14,968,520.0	586,480.0	96.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,700,000.0	3,150,000.0	550,000.0	85.1
210404	Ном, хэвлэл	330,000.0	165,000.0	165,000.0	50.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.0	2,191,000.0	309,000.0	87.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.0	4,862,600.0	637,400.0	88.4
2105	<b>Нормативт зардал</b>	55,536,900.0	52,640,750.0	2,896,150.0	94.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,530,900.0	36,530,900.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	17,006,000.0	14,109,850.0	2,896,150.0	83.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	116,923,700.0	111,376,100.0	5,547,600.0	95.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	107,923,700.0	105,392,100.0	2,531,600.0	97.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.0	1,984,000.0	3,016,000.0	39.7
210604	Урсгал засвар	4,000,000.0	4,000,000.0	00.0	100.0
2107	<b>Томилот, зочны зардал</b>	1,500,000.0	743,000.0	757,000.0	49.5
210702	Дотоод албан томилот	1,500,000.0	743,000.0	757,000.0	49.5
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,157,400.0	2,121,020.0	36,380.0	98.3

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.0	465,920.0	34,080.0	93.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.0	69,300.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.0	67,700.0	2,300.0	96.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.0	25,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	93,100.0	93,100.0	00.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,668,000.0</b>	<b>8,523,236.0</b>	<b>144,764.0</b>	<b>98.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,668,000.0	8,523,236.0	144,764.0	98.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>869,341,400.0</b>	<b>847,444,090.0</b>	<b>21,897,310.0</b>	<b>97.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>827,632,700.0</b>	<b>827,632,700.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	827,632,700.0	827,632,700.0	00.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>41,708,700.0</b>	<b>19,811,390.0</b>	<b>21,897,310.0</b>	<b>47.5</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,708,700.0	19,811,390.0	21,897,310.0	47.5
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>34,271,170.00</b>	<b>34,271,170.00</b>	<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>35.00</b>	<b>35.00</b>	<b>00.00</b>	<b>-</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	00.00	-
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	00.00	-

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>166,688,040.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>166,688,040.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>121,788,040.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>82,108,376.00</b>
210104	Урамшуулал	82,108,376.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>918,959.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	258,959.00
210302	Түлш, халаалт	660,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,039,240.00</b>
210401	Бичиг хэрэг	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,946,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	82,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,044,465.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,044,465.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>677,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	677,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,900,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,900,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>166,688,040.00</b>

1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	166,688,040.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	856,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	283,640.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,618,900.00
131106	Төсвийн урамшуулал	163,929,300.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, Нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, анхан шатны баримт цуглуулалттай холбоотой асуудалд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор О.Оюунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төгс суурь стандарт аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх,нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа Санхүү, Нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/A/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 775.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 208.0 сая төгрөгөөр буюу 11.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		34.3	34.3
Дансны авлага	0.00	43.3	43.3
Бараа материал	60.3	108.4	48.1
Үндсэн хөрөнгө	1747.2	1843.3	96.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1843.3</b>	<b>2051.3</b>	<b>208.0</b>
Хуримтлагдсан үр дүн	1317.3	1318.6	1.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1843.3</b>	<b>2051.3</b>	<b>208.0</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь ЭМД-ын сангаас санхүүжсэн үндсэн дансны үлдэгдэл. Мөн 2021 оны төсвийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн хэлтсээс ковид-19 цар тахлын үеийн бэлэн байдалтай холбогдуулан татан төвлөрүүлэлгүй төрийн сангийн харилцах дансанд 34.3 сая төгрөгийг үлдээж баталгаажуулсан байна.

Авлагын үлдэгдэл 43.3 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын дутуу авсан санхүүжилтээс авлага, тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.1 сая төгрөгөөр өсөж 108.4 сая төгрөг болсон. Дансны үлдэгдэлд материаллаг нөлөөтэй бараа материалын орлогыг харуулбал:

- Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд худалдан авсан 150.1 сая төгрөгийн бараа материал байна.
- Аймгийн эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн өгсөн вакцин, эм тариа, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл 208.4 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2090.8 сая төгрөгөөр буурч 225.4 сая төгрөг болсон. Материаллаг нөлөөтэй үндсэн хөрөнгийн орлогыг харуулбал:

- Аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 11 сарын 15-ны А/116 тушаалаар 12.0 сая төгрөгийн гематологийн аппарат, шээсний хагас анализаторын аппарат авсан байна.
- МонПен төслийн хүрээнд ЭМГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/149 тоот тушаалаар 4.6 сая төгрөгийн хандиваар өндөр, жин хэмжигч, даралтын аппарат, компьютер, сахар хэмжигч, холестерин хэмжигч, шээсний анализатор, сандал ширээ хүлээн авсан байна.
- Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газрын даргын тушаал 2021 оны 12 сарын 07 ний өдрийн А/148 дүгээр тушаалаар 4.7 сая төгрөгийн дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл авсан байна.
- Аймгийн ИТХ -ын тэргүүлэгчдийн 2021 оны 07 сарын 27-ы өдрийн 90 дүгээр тогтоолоор 16.9 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж орлогод авсан байна.
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 20-ын өдрийн 109 дүгээр тогтоолоор 69.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус акталж данснаас хассан байна.
- Сумын ИТХ-ын 2021 оны 06 сарын 15-ны 27 дугаар тогтоолоор 15.0 сая төгрөгийн биет бус хөрөнгө акталж устгасан байна.

Нийт зардал нь өнгөрсөн оноос 2 дахин өссөн. Материаллаг нөлөөтэй гол зардлуудыг харуулбал:

- Ковидтой холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангаас нэмэлт санхүүжилт авч, цалингийн зардал 82.1 сая төгрөг,
- Хангамж бараа материалын зардал 4.0 сая төгрөг,
- Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 34.0 сая төгрөг,
- Бусад урсгал шилжүүлэг 44.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг нийт зарлагыг 869.3 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс 2021 онд 756.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 71.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 41.7 сая төгрөг, нийт 869.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 зориулалт бүхий арга хэмжээг санхүүжүүлэхээр 846.7 сая төгрөгийн санхүүжилт авч 22.6 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Материаллаг нөлөөтэй нэмэлт санхүүжилтийн орлогыг харуулбал:

- Аймгийн ЭМГ-аас ажиллагчдад олгох урамшуулал 44.9 сая төгрөг, сургалт сурталчилгаанд 0.8 сая төгрөг, нэгдсэн эмнэлгээс сорьц тээвэрлэсний зардал 0.2 сая төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.6 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 119.4 сая төгрөг нийт 166.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан. Ковидын тархалттай холбогдсон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 305 хүн өвчилж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 5005 тун вакцинд иргэдийг хамруулж, нийт 208.1 сая төгрөгийн зардал гаргаж нэхэмжилснээс 164.8 сая төгрөгийн санхүүжилт авч ЭМД-ын сангаас 43.3 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант хугацаанд Төрийн сангийн харилцах дансанд 385.6 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх ёстой.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 869.4 сая төгрөгийн 143 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 4 мэдээлэл болох худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 3 худалдан авалтын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинэ дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Монгол улсын Ерөнхий аудиторын 2015 оны 240-р тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан учир 2020 оны А/64-р тушаалаар тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүй итгэл үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитын цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллах нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 18.3 сая төгрөгийн 3 алдаа илрүүлж, 18.3 сая төгрөгийн 1 алдаа залруулж, 2 зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Нийт үнэ төлбөргүй орлогыг 18.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан Нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитаар залруулсан болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### **1.1. Илрүүлэлт:**

2021 онд нийт 869.4 сая төгрөгийн 143 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 4 мэдээлэл болох худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 3 худалдан авалтын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх.

**2.1 Илрүүлэлт**

Татварын ерөнхий хуулийн 15.1.4, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.3 заалтын дагуу эм эмийн зүйлсийн худалдан авалтын И-баримтыг түүвэрлэн шалгахад 9 бэлтгэн нийлүүлэгч 9.8 сая төгрөгийн И-баримт шивээгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж**

Татварын ерөнхий хуулийн 15.1.4, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.3 заалтыг бүрэн хэрэгжүүлж борлуулалт, худалдан авалтын И-баримтыг татварын цахим системд шивж бүрэн оруулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөг/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төв	3	28.1	1	18.3	-	-	-	-	2	9.8

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.